



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БИНДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 08 сарын 26 өдөр

Дугаар А/134

Биндэр сум

Үндсэн хөрөнгө бүртгэлд авах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Мандалхаан, Баянгол, Дэлгэрхаан, Онон багуудад хийгдсэн мал тарилгын хашааг данс бүртгэлд авах арга хэмжээг хавсралтаар баталсугай.

2.Орон нутгийн өмчид эд хөрөнгө бүртгэх ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Өнөболд)-д даалгасугай.


3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Отгонбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ДЭМБЭРЭЛСАЙХАН



Сумын Засаг даргын 2026 оны 08-р сарын 26-ний
өдрийн А/Б дугаар захирамжийн 1-р хавсралт



Бүртгэлд авах хөрөнгө

Д/д	Бүртгэх хөрөнгө	Тоо, хэмжээ	Төсөвт өртөг
1	Мал тарилгын хашаа	4	20,000,000